



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.7.1, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэл хот орчмын амралт, аялал жуулчлалын бүсэд явган аяллын зам тохижуулах ажлаар ирэх БНСУ-ын Чэжү хотын Аялал жуулчлалын газрын төлөөлөгчидтэй хамтран нийслэлийн Налайх болон Баянзүрх дүүрэгт аяллын зам сонгон баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/-д даалгасугай.

2. Төлөөлөгчдөд үйлчлэх автомашины шатахуун, боолтын хоолны зардал болох 560.000 /таван зуун жаран мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА